



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 6/5.

Хэрлэн сум

Б.Оргодолыг туршилтын  
хугацаагаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2 дугаар хавсралтын 2 дахь заалт, 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2015 оны 441 дүгээр тогтоол, 2014 оны "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Б.Оргодолыг аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчоор томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	С.Энхтогоо	Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Ган-очир	Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн
	Н.Шинэбаяр	ЗДТГ-ын нягтлан бодогч
	Т.Баяртуяа	ЗДТГ-ын аж ахуйн нярав
	Т.Бямбадулам	ЗДТГ-ын Архив, бичиг хэргийн эрхлэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

3. Б.Оргодолын үндсэн цалинг ТЗ-6-5 шатлалаар 677436 /зургаан зуун далан долоон мянга дөрвөн зуун гучин зургаан/ төгрөгөөр, төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д даалгасугай.

4. Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Оргодолд үүрэг болгосугай.

5. Б.Оргодолд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА